213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,645,000.00	3,125,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	
213103	Төсвийн санхүүжилт	-	
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,645,000.00	3,125,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,920,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,725,000.00	3,125,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	578,865,700.00	515,748,222.00
223001	Бусад хөрөнгө	578,865,700.00	515,748,222.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	95,000,000.00	14,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	95,000,000.00	14,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,031,284,300.00	2,138,890,436.40
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
310001	Улсын төсвөөс санхүүжих		
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	302,240,100.00	294,240,100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
320001	Орон нутгийн төсвөөс	1,651,371,900.00	1,795,044,846.40
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77,672,300.00	49,605,490.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	314,853,300.00	(36,595,341.78)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(314,853,300.00)	36,595,341.78
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(314,853,300.00)	36,595,341.78
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	315,154,586.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	278,559,244.67
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	67.00	67.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00
610001	Төсвийн байгууллага	3.00	3.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	6.00	6.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.00	32.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	304,614,833.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	49,016,990.00
<b>210</b>	<b>БАРАА , АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	49,016,990.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	514,500.00
210101	Үндсэн цалин	514,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,168.00
210201	Тэтгэврийн даатгал	59,168.00
210202	Тэтгэмжийн даатгал	0
210203	ҮОМШӨ-ний даатгал	0
210204	Ажилгүйдлийн даатгал	0
210205	Эрүүл мэндийн даатгал	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	41,443,322.00
210402	Тээвэр, шатахуун	1,443,322.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	255,597,843.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	255,597,843.00
223001	Бусад хөрөнгө	255,597,843.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	304,614,833.00
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	304,614,833.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	302,097,843.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,516,990.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг чанд сахиж иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,336.9 сая төгрөг болж 1,022.1 сая төгрөгөөр буюу 44.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	315.2	278.6	-36.6
Авлага	153.8	153.5	-0.3
Бараа материал	140.0	163.0	23.0
Үндсэн хөрөнгө	1,705.8	2,741.9	1,036.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,314.8</b>	<b>3,336.9</b>	<b>1,022.1</b>

Өр төлбөр	0.4	202.2	201.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,314.4	3,134.7	820.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,314.8</b>	<b>3,336.9</b>	<b>1,022.1</b>

*Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 278.6 сая төгрөг болж, өмнөх оноос 36.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	315.2	278.6	-36.6
Төгрөг	315.2	278.6	-36.6
Төрийн сангийн харилцах	315.2	278.6	-36.6
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
<b>Дүн</b>	<b>315.2</b>	<b>278.6</b>	<b>-36.6</b>

*Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 278.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 171.1 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 43.6 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 63.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 4.0 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэн. Үүнд:

#### **Аудитын илрүүлэлт:**

**Малчин сумын Засаг даргын тамгын газар:**

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь тэмцээн уралдаан, баяр наадмын шагналын зардал 4.0 сая төгрөгийн гүйлгээг хувь хүний дансаар дамжуулан зарцуулсанд хувь хүний дансаар бэлэн мөнгө гарган зарцуулахгүй байх зөвлөмж өгсөн.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 153.5 сая төгрөг болж, өмнөх оноос 0.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	0.8	4.0	3.2
Хувь хүмүүсээс авах авлага	9.7	10.5	0.8
Зээлийн авлага	143.3	139.0	-4.3
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/		-	
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага			

Дүн	153.8	153.5	-0.3
-----	-------	-------	------

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага буурсан нь голчлон нөлөөлжээ.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 163.0 сая төгрөг болж, өмнөх оноос 23.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	-	-	-
Тусгай зориулалттай материал	-	-	-
Эм боох материал	-	-	-
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	-	-	-
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	-	-	-
<b>Хангамжийн материал</b>			
Бичиг хэргийн материал			
Аж ахуйн материал	11.0	27.9	16.9
Сэлбэг хэрэгсэл			
Түлш, шатах тослох материал	0	0	0
Барилгын засварын материал	0	0	0
Нөөцийн бараа	53.5	58.9	5.4
Бусад хангамжийн материал	15.5	16.2	0.7
Мал амьтад	60.0	60.0	0
<b>Дүн</b>	<b>140.0</b>	<b>163.0</b>	<b>23.0</b>

Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөнд аж ахуйн материал өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна. Мөн нөөцийн бараа өссөн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,741.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,036.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Барилга, байгууламж, орон сууц</b>	<b>1,562.5</b>	<b>2,302.2</b>	<b>739.7</b>
Хуримтлагдсан элэгдэл	-561.7	-618.3	56.6
<b>Авто тээврийн хэрэгсэл</b>	<b>244.2</b>	<b>391.6</b>	<b>147.4</b>
Хуримтлагдсан элэгдэл	-112.0	-161.3	49.3
<b>Машин тоног төхөөрөмж (компьютер)</b>	<b>194.6</b>	<b>257.4</b>	<b>62.8</b>
Хуримтлагдсан элэгдэл	-87.8	-113.2	25.4
<b>Тавилга, аж ахуйн эд хогшил</b>	<b>152.8</b>	<b>195.4</b>	<b>42.6</b>
Хуримтлагдсан элэгдэл	-41.5	-67.6	26.1

<b>Зам, гүүрийн байгууламж</b>	<b>92.6</b>	<b>267.6</b>	<b>175.0</b>
Хуримтлагдсан элэгдэл	-92.6	-93.3	0.7
<b>Түүх соёл, музейн дурсгалт зүйлс</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.00</b>
Дуусаагүй барилга байгууламж	20.9	20.9	0.00
<b>Номын фонд</b>	<b>0.07</b>	<b>0.07</b>	<b>0.00</b>
<b>Бусад үндсэн хөрөнгө</b>	<b>75.2</b>	<b>89.7</b>	<b>14.5</b>
Хуримтлагдсан элэгдэл	-34.7	-41.5	6.8
<b>Программ хангамж</b>	<b>2.4</b>	<b>2.4</b>	<b>0.00</b>
Хуримтлагдсан элэгдэл	-2.4	-2.4	0
<b>Бусад биет бус хөрөнгө</b>	<b>293.1</b>	<b>312.3</b>	<b>19.2</b>
Хуримтлагдсан элэгдэл	0	0	0
<b>Дүн</b>	<b>1,705.8</b>	<b>2,741.9</b>	<b>1,036.1</b>

*Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,741.9 сая төгрөг болж 1,036.1 сая төгрөгөөр өсөхөд ЗДТГ-ын хөрөнгө нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд худалдаж авсан хөрөнгө 396.1 сая, хандив тусламжаар 378.8 сая, бусад эх үүсвэрээс 397.9 сая, нийт 1,312.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, байгууллагын данс хооронд 8.7 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 99.7 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

##### Малчин сумын Засаг даргын тамгын газар:

Орон нутгийн өмчийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр данснаас хасах хөрөнгийн жагсаалтад оруулсан Малчин сумын Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд байсан Багийн төвийн конторын барилга 0.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй байсан тул залруулга хийлгэлээ.

#### **3.5.5 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 202.2 сая төгрөг болж, өмнөх оноос 201.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

##### *Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилтнуудтай холбоотой өглөг	0	2.5	2.5
Байгууллагад төлөх өглөг	0.4	197.5	197.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг			0
Хувь хүмүүст төлөх өглөг	0	2.2	2.2
<b>Дүн</b>	<b>0.4</b>	<b>202.2</b>	<b>201.8</b>

*Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр дансны үлдэгдэл 202.2 сая төгрөг болж 201.8 сая төгрөгөөр өссөхөд байгууллагад төлөх өглөгийн өсөлт голчлон нөлөөлжээ. Энэ нь төсөвт газруудын 11, 12 сарын түлш халаалтын зардал болон зарим зардлын санхүүжилтийн эрх нээгдээгүйгээс шалтгаалжээ.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3134.7 сая төгрөг болж, өмнөх оноос 820.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	460.4	460.4	0.00
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,268.7</b>	<b>2,121.5</b>	<b>852.8</b>
Өмнөх үеийн үр дүн			
Тайлант үеийн үр дүн			
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	585.3	552.8	-32.5
<b>Дүн</b>	<b>2,314.7</b>	<b>3,134.7</b>	<b>820.3</b>

*Эх сурвалж: Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,134.7 сая төгрөг болж 820.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

Малчин сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай А/05 дугаар тогтоолоор Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 667.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 694.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 27.0 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар давуулж биелүүлсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой 6.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэн. Үүнд:

#### Аудитын илрүүлэлт:

Малчин сумын Засаг даргын тамгын газар:

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3.3 сая, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1.0 сая, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах, бэлэг дурсгалын зүйл авахад 2.0 сая, нийт 6.3 сая төгрөгийг зарцуулсанд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг мөрдөж ажиллах, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй ажиллах албан шаардлага өгсөн.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,845.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,845.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,346.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1672.2 сая төгрөгийг урсгал зардалд, 578.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 95.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 302.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,651.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 77.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 294.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,795.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 49.6 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос, нийт 2,138.8 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,175.5 сая төгрөг буюу 92.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 419.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2.5 сая, нийт 421.6 сая төгрөгийг төвлөрүүлэн, 304.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 117.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,455.4 сая төгрөгийн 1 хувиар буюу 34.5 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 27.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,839.2 сая төгрөгийн 1 хувиар буюу 38.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 30.7 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 53.9 сая төгрөгийн 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг ирүүлсэн байна. Үүнд:

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0			
Албан шаардлага	2	53.9	2	53.9	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>53.9</b>	<b>2</b>	<b>53.9</b>	

/сая төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Малчин сумын Засаг даргын тамгын газраас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй 3 багийн сахиул, олон нийтийн цагдаа, сантехникч, нийт 5 ажилтныг гэрээтээр ажиллуулж байна. Дараагийн аудитаар тухайн гэрээт ажилтнуудын орон тоог Төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулсан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзсэн.

#### 4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Малчин сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 3 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 3 байгууллагаас 1 байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгч, 2 байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 10.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 0.2 сая төгрөгийн алдааг залруулж, 6.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

#### Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	3	10.5	1	0.2			1	6.3	1	4.0
2	ИТХ										
3	СДОА										
		<b>3</b>	<b>10.5</b>	<b>1</b>	<b>0.2</b>			<b>1</b>	<b>6.3</b>	<b>1</b>	<b>4.0</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 110.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 61.1 сая төгрөгийн алдааг залруулж, 48.9 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа:

1. Санхүүгийн нэгтгэл тайлангийн бараа материалын тодруулгад Засаг даргын тамгын газрын худалдан авсан сэлбэг хэрэгсэл 9.5 сая, түлш, шатах тослох материал 44.5 сая, нийт 54.0 сая төгрөгийн материалыг хандиваар авсан бараа материалаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх” гэж заасан болон Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.
2. Санхүүгийн нэгтгэл тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгад Засаг даргын тамгын газрын бусад эх үүсвэрээр авсан тавилга хэрэгсэл 7.1 сая төгрөгийн худалдан авсан хөрөнгөд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх” гэж заасан болон Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.

### 5.1 Зөвлөмж

#### Илрүүлэлт:

Халуун усны байр засварлах болон тохижуулах 19.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд 13.3 сая, Хүрэн морьтын давааны хөтлийн тохижилт 19.5 төгрөгийн өртөгтэй ажилд 16.6 сая, Ногоон байгууламжийн хашаа засварлах 3.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд 2.1 сая, нийт 9.4 сая төгрөгөөр дутуу буюу урьдчилгаа төлбөрийн дүнгээр нь гэрээ байгуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4-д “Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг” 3.4.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих” гэж заасанд нийцэхгүй байна.

#### Зөвлөмж:

Цаашид төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөр нь гэрээ байгуулж байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нотлох баримтын хамт манай байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Малчин сумын ТТЗ	2	61.1			2	61.1	2	61.1				
Дүн	2	61.1			2	61.1	2	61.1				

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая  
төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Малчин сумын ТТЗ	1	9.4					1	9.4				
Дүн	1	9.4					1	9.4				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Малчин сум								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Малчин сум								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

/Г.НАМЖИЛ/

2026 оны 03 сарын 24-ний өдөр